



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/584

Мөрөн сум


Газар эзэмших эрх дуусгавар болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/59 дүгээр захирамжийн хавсралтын 2 дахь заалтаар газар эзэмшигч хуулийн этгээд “Далайн-Элбэрэлт” ЗГБХ-нөхөрлөл (4124022)-ны Мөрөн сум 10 дугаар баг 6712016519 нэгж талбарын дугаартай эрүүл мэндийн байгууллагын зориулалтаар эзэмшүүлсэн 3370 м² газрын газар эзэмшигч “Далайн-Элбэрэлт” ЗГБХ-нөхөрлөл нь газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу газар эзэмших эрхийг нь дуусгавар болгож нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.
2. Уг захирамжаар газар эзэмшиж байсан газар эзэмшигч хуулийн этгээд “Далайн-Элбэрэлт” ЗГБХ-нөхөрлөл (4124022)-ын 0000072315 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээ, Мөрөн сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/59 дүгээр захирамжийн хавсралтын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.
3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.
4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6712011343